



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 1197

Эг

**Хуулийн хэрэгжилтийг хангаж
ажиллах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.2, 70.1.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/350 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 27, 28, 29-ний өдрүүдэд сумын хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг, 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр спорт, соёл урлаг, үзвэр үйлчилгээ зэрэг олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулахыг хориглосугай.

2. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэсгийн Төлөөлөгч, ахлах дэслэгч (Р.Болор-Эрдэнэ)-д, багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Шажинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНСҮХ

232401170